

**“МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ
(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)**

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХХК

Энэхүү Дүрмийг Хувьцаа эзэмшигчдийн
2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн
ээлжит бус хурлын 23/ХЭХ/14 тоот
шийдвэрийн хавсралтаар батлав

ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨГЖИЛЭГЧ АГЕНЦИЯТ
УЛСЫН БҮРГЭДЖИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улсын бүртгэлийн

нэг. нийтлэг үндэслэл ... 9007 001019

БҮРГЭВ
2023.09.12 сар 00 дугаарт

УЛСЫН БҮРГЭГЧ 411

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ... 9007 001019

- 1.1. “Монложистикс Холдинг” компани нь нээлттэй хувьцаат компани/цаашид “компани” гэх/ мөн.
- 1.2. Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Унэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.3. Компанийн оноосон албан ёсны нэр:
 - 1.3.1. Монгол хэлээр: **“Монложистикс Холдинг” Хувьцаат компани**
 - 1.3.2. Англи хэлээр: **“Monlogistics Holding” Joint stock company /JSC/ гэнэ.**
- 1.4. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд нээлттэй ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- 1.5. Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.
- 1.6. Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн **удирдах зөвлөл /цаашид “ТҮЗ” гэх/ баталж**, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг зөвхөн “Монложистикс Холдинг” ХК эдэлнэ.
- 1.7. Компани нь үйл ажиллагаандaa нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болон компанийн засаглалын шилдэг жишигийг удирдлага болгоно.
- 1.8. Компани нь хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна.
- 1.9. Компанийг энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөх болон өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.

ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

- 2.1. Компани нь үүсгэн байгуулагдсан үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 2.2. Компани нь өөрийн тусгаарласан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ.
- 2.3. Компани нь өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээх ба үйл ажиллагаанаас бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцаж, шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцох чадамжтай байна.
- 2.4. Компани нь өөрийн материаллаг болон мөнгөн хөрөнгөтэй байх ба тэдгээрийг ашиглах, захиран зарцуулах болон бусад эрхийг хуульд заасны дагуу эдэлнэ.
- 2.5. Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 2.6. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод зохион байгуулалтын баримт бичгийн дагуу үйл ажиллагаа явуулж, тайлагнана.

ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 3.1. Тээвэр, ложистикийн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулах, бизнесийн олон талт, мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.
- 3.2. Компанийн эрхэм зорилго нь: Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд
- 3.3. Компанийн алсын хараа: Бид орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр сууринсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол улсыг Ази Европтой холбосон ложистик төв болгоно.
- 3.4. Компани нь хуулиар хориглоогүй дараах төрлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ:
 - 3.4.1. Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
 - 3.4.2. Бизнесийн зөвлөгөө өгөх
 - 3.4.3. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
 - 3.4.4. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа;
- 3.5. Монгол улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагааг эрхлэхдээ холбогдох тусгай зөвшөөрөл авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхэлнэ.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- 4.1. Компанийн зарласан энгийн хувьцаа нь нэг бүрийн 30 /гучин/ мөнгөний нэрлэсэн үнэ бүхий 395,858,822 /турван зуун ерэн таван сая найман зуун тавин найман мянга найман зуун хорин хоёр/ ширхэг хувьцаанаас бүрдэнэ.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 30 /гучин/ мөнгөний нэрлэсэн үнэ бүхий 395,858,822 /турван зуун ерэн таван сая найман зуун тавин найман мянга найман зуун хорин хоёр/ ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
- 4.3. Компанийн өөрийн эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж тооцно.
- 4.4. Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэж үзнэ.
- 4.5. Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах /хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар/ тухайн асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлнэ.
- 4.6. Хэрэв ийнхүү бага болсон нь алдагдалтай ажилласнаас шалтгаалсан бөгөөд дахин хөрөнгөжүүлэх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар шийдвэрлэх боломжгүй бол компанийг татан буулгах асуудлыг ХЭХ-аар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.7. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан үндэслэлээр нэмэгдүүлж, хорогдуулна.
- 4.8. Компани нь өөрийн хувьцаа болон бусад үнэт цаасны хадгаламж, үнэт цаас эзэмшигчийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

ТАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

5.1. Хувьцаа эзэмшигч

- 5.1.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь хувь хүн, хуулийн этгээд байж болно.

59, 378, 822

- 5.1.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
 - 5.1.3. Компанийн саналын эрх бүхий энгийн хувьцааны тав ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд нэрээ дэвшүүлэх болон өөрийн төлөөллийг нэр дэвшүүлэх эрхтэй.
- 5.2. Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага**
- 5.2.1. Компанийн хөрөнгө нь эд хөрөнгө болон эд хөрөнгийг эрхээс бүрдэх ба эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
 - 5.2.2. Компани хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй ба Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.
 - 5.2.3. Компанийн хувьцаа эзэмшигчид гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хувь хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 5.3. Компанийн засаглал /удирдлага/ нь дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:**
- 5.3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “ХЭХ” гэх/
 - 5.3.2. Төлөөлөн удирдах зөвлөл
 - 5.3.3. Гүйцэтгэх удирдлага

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 6.2. ХЭХ нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх ба ээлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.
- 6.3. Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэхдээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болох ба Компанийн тухай хуульд заасан үндэслэл бий болсон тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
- 6.4. Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг мэдээлэл, технологийн шийдэл ашиглан зайнаас буюу цахимаар зохион байгуулж болно.
- 6.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахгүйгээр эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэр гаргаж болно.
- 6.6. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.
- 6.7. ХЭХ хуралдуулах тухай шийдвэр гаргах, ХЭХ-ын хурал зохион байгуулах арга, хэлбэрийг тодорхойлох, ХЭХ-д бэлдэх, хурлын зар мэдээг хүргэх, хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэхтэй холбогдсон нарийвчилсан харилцааг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон Компанийн ТУЗ-өөс баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам”-аар зохицуулна.
- 6.8. ХЭХ-д компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны дийлэнх олонх (66.67%) болон түүнээс дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 6.9. Дараах асуудлууд нь зөвхөн ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
 - 6.9.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найрууллыг батлах;
 - 6.9.2. Нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлен байгуулах;
 - 6.9.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
 - 6.9.4. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрх эдлүүлэх эсэх;
 - 6.9.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 6.9.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;

- 6.10. Дараах асуудлууд нь зөвхөн ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 6.10.1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх, батлах;
 - 6.10.2. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг шийдвэрлэх;
 - 6.10.3. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 6.10.4. Компанийн өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх;
 - 6.10.5. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 6.10.6. ТУЗ-ийн шийдвэрээр ХЭХ-аар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 6.11. ТУЗ-ийн гишүүдийг томилох, чөлөөлөх бүрэн эрхийг ХЭХ хэрэгжүүлэх ба ТУЗ-ийн гишүүнийг сонгохдоо санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.

ДОЛОО. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 7.1. ХЭХ-ын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 7.2. ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг хариуцлага ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх, нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.
- 7.3. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь энэхүү дүрэм болон Компанийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байна.
- 7.4. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхыг хараат бус гишүүн байлгахыг зорино.
- 7.5. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна.
- 7.6. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулаагүй тохиолдолд энэхүү журмын 7.5-д заасан бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.
- 7.7. ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан компанийн эрх ашгийг тэргүүн ээлжид эрхэмлэдэг этгээд байвал зохино.
- 7.8. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан этгээд байх ба ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичгийг ТУЗ батлан мөрдүүлнэ.
- 7.9. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байхаас гадна Компанийн тухай хууль болон Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нэмэлт үүргийг хүлээнэ.
- 7.10. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна, дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 7.10.1. Компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
 - 7.10.2. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;
 - 7.10.3. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;
 - 7.10.4. Хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон компанийн засаглалын жишигийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг бүрэн хүргэх;
 - 7.10.5. Өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх.

- 7.11. ТУЗ-ийн гишүүн нь үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно.
- 7.12. ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно.
- 7.13. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, ТУЗ-ийн зөвшөөрснөөр тодорхой асуудлаар тушаал, шийдвэр гаргах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- 7.14. ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр ХЭХ-ын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 7.14.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратеги болон жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах, өөрчлөлт оруулах;
 - 7.14.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, эчнээ санал хураалт явуулах болон цахимаар хурал хуралдуулах шийдвэр гаргах;
 - 7.14.3. ХЭХ-ын хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 7.14.4. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах;
 - 7.14.5. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, тодорхой үнийн дүнгийн хэмжээнд эд хөрөнгийн үнийг тодорхойлох эрхийг Гүйцэтгэх удирдлагад шилжүүлэх;
 - 7.14.6. Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
 - 7.14.7. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
 - 7.14.8. Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох;
 - 7.14.9. Компанийн дотоод хяналтын алба, нэгжийг томилох, цалин хөлсийг тогтоох;
 - 7.14.10. Ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;
 - 7.14.11. ТУЗ-ийн үйл ажиллагааны болон компанийн сайн засаглалын зарчмуудыг хэвшүүлэхтэй холбоотой “Компанийн засаглалын кодекс”-т заасан бусад дотоод журмуудыг батлах;
 - 7.14.12. Зарласан хувьцааны тоо, төрөлд багтаан хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаас нэмж гаргах шийдвэр гаргах, худалдах журмыг тогтоох;
 - 7.14.13. Өөрийн гаргасан хувьцаа болон бусад үнэт цаасыг эргүүлэн авах эсхүл худалдан авах шийдвэр гаргах;
 - 7.14.14. Тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулах, татан буулгах, хороодын чиг үүргийг нэгтгэх, салгах;
 - 7.14.15. Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн дарга, захирлыг томилох;
 - 7.14.16. Компанийн болон өөрийн 100 хувийн охин компанийн, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлэх эрх хэмжээг тусгасан “Эрх мэдлийн хуваарилалт”-ыг батлах;
 - 7.14.17. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 7.14.18. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 7.14.19. Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 7.14.20. Гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хувь нийлүүлэн хөрөнгө оруулах, компанийн хөрөнгөөр баталгаа гаргах;
 - 7.14.21. Компанийн ажиллагдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шинээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 7.14.22. Компанийн охин компанийн хувьд түүний хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
 - 7.14.23. Компанийн 100 хувийн охин компанийн ТУЗ-ийг томилох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох;
 - 7.14.24. Компанийн 100 хувийн охин компанийн ногдол ашиг тараах эсэх тухай асуудлыг шийдвэрлэх;

- 7.14.25. Компанийн 100 хувийн охин компанийд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 7.14.26. Шинээр охин компани байгуулах;
- 7.14.27. Бусад компанийд хөрөнгө оруулах, компани худалдан авах;
- 7.14.28. ХЭХ-аас эрх олгосон бусад асуудал.
- 7.15. ТУЗ-ийн хурлыг жилд 4-өөс доошгүй удаа буюу 3 сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.
- 7.16. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ албан бичгийн хэвлэмэл хуудас ашиглана.
- 7.17. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон дотоод хяналтын нэгж, хараат бус аудитын байгууллагын санаачилга, шаардлагаар хуралдуулна.
- 7.18. ТУЗ нь эчинээ санал хураалт явуулах замаар шийдвэр гаргаж болох ба энэ тохиолдолд ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх санал ирүүлснээр шийдвэрийг хүчинтэйд тооцно.
- 7.19. ТУЗ-өөс тодорхой асуудлыг шийдвэрлэх эрхийг ТУЗ-ийн дэргэдэх аль нэг Хороонд олгож болно.
- 7.20. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Компанийн тухай хуульд тусгайлан заасан зарим асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй гаргана.
- 7.21. Тухайн шийдвэрлэж буй асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй бол шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 7.22. ТУЗ-ийн гишүүн нь саналын эрхээ бусад гишүүд болон гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 7.23. ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос хоёр дахин багассан тохиолдолд компани нь гурван сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 7.24. ТУЗ-ийн дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 7.24.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэлийг хетлүүлж хяналт тавих, үнэн зөвийг хариуцах;
 - 7.24.2. ХЭХ-ын болон ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 7.24.3. Хувьцаа эзэмшигчдийн жил бүрийн ээлжит хурлын бэлтгэлийг энэ дүрэмд заасны дагуу хангаж байгаа эсэхэд хяналт тавих, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргасан байх асуудлыг ТУЗ-ийн дарга биечлэн хариуцах;
 - 7.24.4. Охин компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаанд Компанийг төлөөлөх, гарын үсэг зурах;
 - 7.24.5. ТУЗ-өөс олгосон, хариуцуулсан бусад асуудал.



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

- 7.25. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн даргын санал болгосон этгээдийг ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын асуудлаар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. Нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.
- 7.26. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуульд заасан чиг үүрэгтэй байх бөгөөд түүнийг сонгох, үйл ажиллагааг нь зохицуулах хянахтай холбоотой нарийвчилсан асуудлыг “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтооно.

НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

- 8.1. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын хороотой байна.
- 8.2. ТУЗ-ийн хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна.
- 8.3. Компанийн ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажиллаж болно.

- 8.4. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь үйл ажиллагааны тайлан гаргах бөгөөд жилд хоёроос доошгүй удаа ТУЗ-д танилцуулна.
- 8.5. ТУЗ-ийн аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргшсэн байна.
- 8.6. ТУЗ-ийн дарга нь Аудитын хорооны дарга байхыг хориглоно.
- 8.7. ТУЗ-ийн дэргэдэх аудит, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороод нь Компанийн тухай хууль болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах ба холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 8.8. Аудитын хорооны дарга нь компанийн хөндлөнгийн аудитортай аливаа холбоогүй, сүүлийн гурван жилийн хугацаанд тухайн хөндлөнгийн аудитын компанийд ажиллаж байгаагүй байна.

ЕС. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

- 9.1. Дараах албан тушаалтнууд нь Компанийн эрх бүхий албан тушаалтан байна.
 - 9.1.1. ТУЗ-ийн дарга, гишүүд;
 - 9.1.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
 - 9.1.3. Гүйцэтгэх захирал;
 - 9.1.4. Ерөнхий нягтлан;
 - 9.1.5. ТУЗ-өөс эрх бүхий гэж тогтоосон бусад албан тушаал.
- 9.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Компанийн дотоод зохион байгуулалтын баримт бичиг, Компанийтай байгуулсан гэрээнд заасан эрх эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 9.3. Эрх бүхий албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа, шийдвэрийн улмаас бусад этгээдэд хохирол учирсан тохиолдолд уг шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтан учирсан хохирлыг гагцхүү өөрөө хариуцан нөхөн төлнө.
- 9.4. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гүйцэтгэх удирдлага

- 9.5. Компанийн гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан “Эрх мэдэл хуваарилалтын матриц” болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулна.
- 9.6. Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах журам, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэргийг ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээгээр зохицуулна.
- 9.7. Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх ба уг этгээд нь Компанийн “Гүйцэтгэх захирал” байна.
- 9.8. Компанийн гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болох ба ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.
- 9.9. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр өөр компани аж, ахуй нэгжид эрх бүхий албан тушаалтнаар ажиллахыг хориглоно.
- 9.10. ТУЗ компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд ТУЗ-ийг төлөөлөн дарга гарын үсэг зурах ба гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг бусад шаардлагатай асуудлыг тусгасан байна.
- 9.11. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгогдсон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнэ.
- 9.12. Гүйцэтгэх захирал нь өөрт олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр нь “Тушаал” хэлбэртэй байх ба тухайн тушаалынхаа биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллах эрхтэй.
- 9.13. Гүйцэтгэх захирал нь Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа Хувьцаа эзэмшигчдийн эрх ашигийг нэн тэргүүнд тавьж, зохистой эрсдэлийн түвшинд компанийн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, хууль дээдлэх, бизнесийн ёс зүйг эрхэмлэн дээдлэх зэрэг зарчмыг баримтлан ажиллана.
- 9.14. Гүйцэтгэх захирал ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

АРАВ. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Дотоод аудитын хяналт

- 10.1. Компанийн дотоод аудитын нэгж нь компанийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмол хянах ба энэхүү үйл ажиллагааг ТУЗ өөрийн аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлж, үр дүнг нь сайжруулж ажиллана.
- 10.2. Компанийн дотоод аудитын нэгжийг хэрэгжүүлэх этгээдийг Аудитын хорооноос санал болгосны дагуу ТУЗ томилно.
- 10.3. Дотоод аудитын нэгжийн нь зохих мэдлэг, чадвар, туршлагатай байх ба ТУЗ болон түүний дэргэдэх холбогдох хороотой шууд харилцаж, тайлагнана.
- 10.4. Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг ТУЗ-өөс баталсан Дотоод аудитын бодлого, журмаар зохицуулна.

Дотоод хяналт

- 10.5. Компани нь дотоод, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх ба Гүйцэтгэх захирал дотоод хяналтын нэгжийг томилж чөлөөлнө.
- 10.6. Дотоод хяналтын нэгж нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн зохих мэдлэг, туршлагатай ажилтан эсхүл ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-ийн баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 10.7. Гүйцэтгэх захирал дотоод хяналтын албаны мэдээлэл, хяналт, шалгалтын дүнг болон Компанийн дотоод болон хөндлөнгийн аудитын зөвлөмж, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ТУЗ, түүний дэргэдэх холбогдох хороонд танилцуулж, тайлагнан ажиллана.

Хөндлөнгийн аудитын хяналт

- 10.8. ТУЗ-ийн Аудитын хороо нь Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулж, ТУЗ-д хүргүүлнэ.
- 10.9. Аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.
- 10.10. Компанийн жилийн санхүүгийн тайланда дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 10.11. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний аудитын хорооны шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн саналаар хэдийд ч хийж болно.
- 10.12. Аудитын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүний захиалж, гэрээ байгуулж хийлгэсэн хувьцаа эзэмшигч хариуцаж төлнэ. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компанийд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнэ.
- 10.13. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд гаргасан дүгнэлтийнхээ талаар тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.
- 10.14. Дараах этгээдийг компанийн аудитораар сонгон ажиллуулахыг хориглоно:
 - 10.14.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
 - 10.14.2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хувьцаа эзэмшигч, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;
 - 10.14.3. Компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.

**АРВАН НЭГ. КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСЫГ ГАРГАХ
ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ**

- 11.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хөрвөх үнэт цаасыг гаргаж болно.
- 11.2. Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахаар, энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Хороонд бүртгүүлнэ.
- 11.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй үнийн дүн бүхий өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлгөдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.
- 11.4. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах, худалдах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болох ба тухайн асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 11.5. Компанийн хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу Компанийн ТУЗ тогтооно.
- 11.6. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болох бөгөөд мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэх тохиолдолд үнэлгээг тогтоохдоо ТУЗ нь мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.
- 11.7. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу брокерт захиалга өгөх замаар худалдан авч болно.
- 11.8. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болох ба эргүүлэн худалдан авах үнэт цаасны зах зээлийн үнийг ТУЗ тогтооно.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН

- 12.1. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.
- 12.2. Компани нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлант болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг ерөнхий нягтлан бодогч гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.
- 12.3. Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хетелж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.
- 12.4. Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж ХЭХ-д оруулж, хэлэлцүүлнэ.
- 12.5. Компанийн гүйцэтгэх захирал нь энэхүү дүрмийн 12.3-т заасан мэдээлэлтэй танилцах боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангана.
- 12.6. Компани нь Хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт мэдээллийг, санхүүгийн тайлангийн хамт дээрх байгууллагуудад болон олон ийтэд хүргүүлэх, танилцуулах үүрэгтэй.

АРВАН ГУРАВ. НОГДОЛ АШИГ

- 13.1. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлэл хүргүүлнэ.
- 13.2. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 13.3. Компани “Ногдол ашгийн бодлого”-той байх ба тус бодлогын баримт бичгийг ТУЗ батална.
- 13.4. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 13.5. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг ХЭХ-д тайлагнана.

АРВАН ДӨРӨВ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Их хэмжээний хэлцэл

- 14.1. Их хэмжээний хэлцлийг тодорхойлоходо Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны баримтлах ба ТУЗ нь их хэмжээний хэлцлийг тодорхойлох, шийдвэрлэх асуудлыг тусгасан баримт бичгийг батлан, мөрдүүлж болно.
- 14.2. Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэй гаргах ба ийнхүү гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг ХЭХ-д оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.
- 14.3. Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

- 14.4. Компани нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг тодорхойлох болон хэлцэл хийхдээ Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлах ба ТУЗ нь сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах, тодорхойлох нарийвчилсан харилцааг тусгасан баримт бичгийг батлан, мөрдүүлж болно.
- 14.5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам зөрчсөний улмаас компанийд хохирол учруулсан бол хэлцэл хийхэд оролцсон сонирхлын зөрчилтэй эрх бүхий алан тушаалтан уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 14.6. Компанийн тухай хуулийн 92.3-т заасан тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг ХЭХ-аар шийдвэрлэнэ.

АРВАН ТАВ. КОМПАНИЙН ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТАТАН БУУЛГАХ

- 15.1. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 15.2. Компанийг дараах тохиолдолд ХЭХ-ын шийдвэрээр татан буулгана.
 - 15.2.1. Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;
 - 15.2.2. Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр;

АРВАН ЗУРГАА. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 16.1. Энэхүү дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор баталж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 16.2. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 16.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

--ooOoo--

